



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/314

Чингис хот

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
Хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.11, 7.12 1-7.12.3, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/04, А/187 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Норовлин, Галшар, Дархан суманд гоц халдварт хонины цэцэг, шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс хорио цээр, хязгаарлалтын дэглэм цуцлагдах хүртэл хугацаанд бусад аймаг болон Улаанбаатар хотруу мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл хийхийг хориглосугай.

2.Гоц халдварт өвчний хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаа сумдын өвчин гараагүй эрүүл бүсээс зах зээлд борлуулах мах, түүхий эд бүтээгдэхүүнийг Чингис хотруу нэвтрүүлэхийг зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат), Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011683